

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН



Улаанбаатар хот
2024 он

Ц.Цэрэнчимэд

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦОО

Улаанбаатар хот

2024 он

ӨМНӨТГӨЛ

„Монголын улс төрийн тогтолцоо“ хэмээх энэхүү ном нь манай улсын ардчилсан хөгжил, түүний алдаа оноонд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон онол болон фактад суурилсан судалгааны ажил юм. Аливаа улсын улс төрийн тогтолцооны хамгийн гол цөм нь тус улсын Үндсэн хууль байдаг. Манай улсад Үндсэн хуульт ёс хөгжөөд 100 гаруй жилийн нүүрийг үзэж байна гэдэг. Үүнээс 1992 оны Үндсэн хууль өнөөгийн Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралыг зохицуулж буй гол баримт бичиг юм. Иймд энэхүү номд 1992 оны Үндсэн хуулийг түлхүү түшиглэх болно. Үүнээс гадна Үндсэн хуулийн институтууд, тэдний хоорондын харилцаа, шүүх засаглал, улс төрийн нам, сонгуулийн тогтолцоо, сонгогчдын төлөв байдал, иргэний нийгмийн хөгжил, чөлөөт хэвлэл, нутгийн өөрөө удирдах ёс зэрэг улс төрийн тогтолцоонд хамаарал бүхий системүүдийн талаар дэлгэрэнгүй бичиж тайлбарлахыг хичээлээ. Ингэхдээ Монголчууд бидний алдаа оноо юунд байв? Яагаад судлаачид Монголын ардчиллыг „алдаатай“ хэмээн тодорхойлох болов? Энэ нь юугаар илэрч байна вэ гэх асуултад өөрийн өнцгөөс хариулахыг оролдоно.

Энэхүү номын удаах нэгэн чухал зорилго бол иргэдийн улс төрийн боловсрол. Тодруулж хэлбэл иргэдийн, тэр дундаа залуучуудын ардчилсан боловсролыг тэлэхийг зорилоо. Учир

нь ардчилал яг үнэн хэрэгтээ маш нарийн төвөгтэй, сэтгэл хөдлөлд түргэн автамтгай, хольбиромтгой засаглалын хэлбэр. Ардчилал 300 жил гаруй хөгжсөн Америкт ч өнөөдрийг хүртэл тийм л байна. Иймд уншигч Танд ардчиллын онолын тухай зарим ойлголтыг өгч, зарим Монголын түүх, онцлогийг дурдаж, Монголдоо ардчилагчдыг олноор бойжуулах зорилго бүхий ном юм. Ингэхдээ чухам ардчилсан дэглэмийн сул талыг харуулж, баруун Европт түүнийг хэрхэн залруулахыг хичээдэг болох талаар бодит шижээ дээр дурдан тайлбарлах болно.

Зарим судлаачид Монголын өнөөгийн ардчилсан хөгжлийг сэтгэл түгшин ажиглаж байна. Учир нь Монгол Улс ардчиллын олон үзүүлэлтээр хойш ухарсан, чанар муудсан он жилүүдийг үдэж байна. Сүүлдээ ардчилал хөгжлийг хурдасгуур уу эсвэл хойш татагч уу хэмээн асуух болжээ. Эрх мэдлийн хуваарилалт, олон ургалч үзэл, олон намын тогтолцоо, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө энэ бүхэн ардчиллын үнэт зүйл.

Номыг санаачлагч

НЭГ.

УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ҮНДСЭН СУУРЬ

а. АРДЧИЛСАН ҮНДСЭН ХУУЛЬ

I. Ардчилсан Үндсэн хуулийн урьдач нөхцөл

Одоогийн хүчин төгөлдөр мөргөгдөж буй Үндсэн хуулийн мөн чанарыг гүйцэд ойлгохын тулд түүний урьдач нөхцөл байдлыг чамгүй сайн биш юмаа гэхэд гадралдаг байх учиртай. Ер нь түүхэн үйл явдлыг өнөөгийн өнцгөөс тайлбарлаж, үнэлэлт дүгнэлт өгөх нь туйлын учир дутагдалтай юм. 1992 оны Үндсэн хуулийг магтан сайшаах эрдэмтэн судлаачид байхад шүүмжлэх хүмүүс ч цөөнгүй бий. Гэхдээ уг Үндсэн хуулиар Монгол Улс анх удаа төрийн эрх мэдлийг хуваарилаж, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, олон ургалч үзэл, намын тогтолцоо, чөлөөт хэвлэл, сонгууль зэрэг ардчиллын олон суурь зарчмыг нутагшуулж чадсан нь маргаангүй үнэн юм. Хэдийгээр өнөөдөр дээрх дурдагдсан ардчиллын зарчмууд олон зуун жил ардчилал хөгжсөн орнуудын адил манайд хэрэгжиж чадахгүй байгаа ч Монголчуудын оюун санаанд аль хэдийн төлөвшиж, бидний амьдралын хэв маягийн салшгүй хэсэг болсныг дурдах нь зүйтэй. Монголын ардчиллын өмнөх нөхцөл байдал амар байгаагүй.

Тэртээ 1911 онд Манж чин улс дотоодын нийгмийн хагарал мөргөлдөөн, манжийн эсрэг бослого тэмцэл, эдийн засгийн мухардал, хүнсний хомсдол, байгалийн гамшиг зэрэг нь олон хүчин зүйлээс болж түүний эсрэг чиглэсэн хүчтэй зохион

байгуулалттай хөдөлгөөн өрнөлгүйгээр нуран унажээ. Ийнхүү 1911 оны хоёрдугаар хагаст өрнөсөн үйл явдал Ар Монголчуудад хүчтэй нөлөө үзүүлж, 1691 оноос хойш Манж чин улсын эрхшээлд байсан Монголчуудын хувьд цаг үеийг тусгаар улсаа сэргээн мандуулах түүхэн боломж тохиожээ. Монголчуудын тусгаар тогтнох үйл хэргийг тухайн үеийн Орос улс ч дэмжихээ илэрхийлж байв. Гэхдээ төрт улсаа дахин зогцлоох хүсэл эрмэлзэл тухай үед нийгмийн бүхий л үе давхрагт биелээ олсон байснаас гадна Монголчуудын олон зуун жилийн төрт ёсны уламжлал тусгаар улс болох, үндэстэн улсаа байгуулах суурь нь болж өгсөн юм. 1911 оны 12-р сарын 29-нд Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон Монголчууд үндэсний тусгаар тогтнолоо зарласан түүхтэй.

1921 оны Ардын хувьсгал нь 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шууд үргэлжлэл болж, Монголын үндэсний төр засгийг дахин сэргээж, Монголчууд тусгаар тогтнолоо бататган бэхжүүлж олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, үндэсний дэвшилд хүрэх үйл явцыг эргэлт буцалтгүй болгосон юм. Энэ бүхнийг Зөвлөлт Оросулсаас цэрэг, улстөрийн дэмжлэг тусалцаагүйгээр амжилттай хэрэгжүүлэх боломжгүй байсан ба энэ тусалцаа дэмжлийг даган тус улсын улс төрийн онол, үзэл суртал, дэглэм Монголд аажмаар орж ирэх, хүлээн зөвшөөрүүлэх, тулгах улс төрийн давхар бодлого байсан нь тодорхой байлаа. Тухайн үед Монголын нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин сул дорой, ард иргэдийн амьдрал туйлын ядуу, Баруун Европт өрнөөд удсан аж үйлдвэржилтийн хөгжил дэвслээс хол хоцрогдсон байдал нь Монголын хөрсөнд тоталитар дэглэм, улмаар Зөвлөлт Оросын социалист дэглэм 70 гаруй жил орших таатай урьдач нөхцлийг бүрдүүлж өгчээ. Ийнхүү Монгол улс Азидаа анхны социалист улс болж, ЗХУ-ын гадаад бодлогод чухал үүрэг гүйцэтгэх болсон байна. Тодруулбал Монголыг нэг талаас Ази, Африкийн зарим улсад капиталист бус замаар хөгжиж буй амжилттай үлгэр шижээ орноор суртачилах нөгөө талаар ЗХУ-ын хувьд Монгол бол хамгийн тохиромжтой буфер бүс юм.¹

1 <https://www.bpb.de/shop/zeitschriften/apuz/archiv/529949/die-mongolische-volksrepublik-sibirisches-vorfeld-der-udssr/> (12.12.2024);

Ийнхүү БНМАУ нь ЗХУ-ын социалист дагуул улс (Satellit) болон хөгжих болсон төдийгүй улс төр, төрийн тогтолцооны хувьд Зөвлөлтийн загварын багахан өөрчилсөн хуулбар улс болсон юм. 1940 оноос хойш Монголын улс төрийн систем хэдэн арван жил зогсонги байдалд ороод зогсохгүй газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалан энэ хугацаанд хэт тусгаарлагдмал хаалттай байдалд Монгол Улс орсон байв. Зөвлөлтийн зөвлөхүүд Москвагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянадаг бол эрх баригч МАХН-ын орон нутгийн удирдах албан тушаалтнууд хэрэгжилтийг баталгаажуулдаг байлаа. Зөвлөлтийн намын сургуулийг төгсөгчдийн хувьд марксист/ленинист үзэл баримтлал, ЗХУ-д үнэнч байх нь тэдний карьерын шат гэдгийг Монголын эрх баригчид сайн мэддэг байв. Бээжинтэй үзэл суртлын зөрчилдөөний үр дүнд Москва 1960-аад оноос хойш Монголыг Хятадаас хамгаалах фронтын шугам болгон хөгжүүлсэн юм. 1967 оны нууц гэрээний дагуу хэдэн арван мянган цэрэг, хамгийн орчин үеийн зэвсгийн систем бүхий Зөвлөлтийн элит ангиуд Хятадтай хиллэдэг хилээс холгүй байлдааны байнгын бэлэн байдалд байлаа.

КГБ болон ГРУ нь улс орон даяар өргөн сүлжээтэй байсан ба Монголын аюулгүй байдлын бүх аппаратад шийдвэрлэх нөлөөтэй байв. Брежневийн сургаалын нөхцөлд Монголын гадаад бодлого гагцхүү Москвагийн тогтоосон хүрээнд явагдана. Тиймээс энэ нь ЗХУ-ын гадаад бодлогын хэрэгсэл төдий болж байсан бөгөөд үндэсний ашиг сонирхолдоо чиглэх нь ховор байсан юм.

Монгол Улс 1962 онд Москвагийн шууд хүсэлтээр Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (СЭВ-Комекон)-д элссэн Азийн анхны орон болсны дараа үйлдвэржилтийн томоохон хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн юм. Хотжилт, үйлдвэржилтийн үр дүнд Дархан, Эрдэнэт зэрэг аж үйлдвэрийн хотууд бий болж, нэлээд томоохон дэд бүтэц бий болжээ. Хожим нь эдгээр хотууд нь нийслэл Улаанбаатартай хамт «алтан гурвалжин» буюу Монголын эдийн засгийн ноён нурууг бүрдүүлсэн бөгөөд энэ нь стратегийн шалтгаанаар анхнаасаа дэд бүтцийн хувьд

хойд зүгт, ЗХУ руу чиглэж байсан юм.²

МАХН намынхаа их хурлаараа 1970-аад оны эцэс гэхэд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг байсан улс орныг аж үйлдвэр хөдөө аж ахуйтай улс болгох зорилтоо зарлав. Гэхдээ энэ хичээлийг төлөвлөх, хэрэгжүүлэх нь Монголын гарт бус, Зөвлөлтийн мэдэлд байв. Москва дахь Улсын төлөвлөлтийн хороо нь СЭВ-ийн улс орнуудын эдийн засгийн төлөвлөгөөг зохицуулахад төвлөрсөн зохицуулах үүрэг гүйцэтгэсэн. Тиймээс ч хоёр талын төлөвлөлтийн хэлэлцээрээр Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, цар хүрээ, хурдыг тодорхойлсон. ЗХУ болон СЭВ-ийн санааг ойлгоход хялбар байв. Монгол Улс хүнс, цахилгаан, дулааны эрчим хүч, барилгын материалаар өөрийгөө хангаж, малын гаралтай түүхий эдээ үндэсний хөнгөн үйлдвэрт боловсруулж чадах хэмжээнд үйлдвэржсэн байх ёстой байв. Тэдний олборлох үйл ажиллагаа нь нүүрс, зэс, алт, молибден, висмут, уран, жонш, цагаан тугалга, цайр, вольфрам, газрын тос гэх мэтийг олборлож, зарим хүдрийг дотооддоо баяжуулж, дараа нь СЭВ-ийн орнууд, ялангуяа ЗХУ-д экспортлох явдал байв.

1975 онд гэхэд аж үйлдвэр анх удаа хөдөө аж ахуй салбараас өндөр буюу 24.7 хувь буюу нийт орлогынхоо дийлэнх хувийг үйлдвэрлэжээ. Энэхүү бүтээн байгуулалт нь Монголын өмнөх хөгжлийн түвшинтэй харьцуулахад тодорхой ахиц дэвшил болсон хэдий ч Монгол ЗХУ болон СЭВ-ийн түүхий эдийн нийлүүлэгч орон болсон байлаа. Монголын үйлдвэрлэл дэлхийн зах зээлд гарах боломжгүй ба Москва ч үүнд огтоос сонирхолгүй байсан юм.

БНМАУ 1962 оны 6-р сарын 7-ны өдөр Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн гишүүнээр элссэн байна. Үүний зэрэгцээ БНМАУ-д хөдөө аж ахуй, үйлдвэрийн салбаруудыг ЗХУ болон бусад социалист улсуудын эдийн засаг болон мэргэжилтний хүчээр эрчимтэй хөгжүүлж эхэлсэн байна. Эдгээрийн үр дүнд Монгол нь социалист улсуудад хөдөө аж ахуйн болон уул уурхайн хямд түүхий эд нийлүүлэгч түүхий эдийн бааз

2 Udo Barkmann (2023): Transformation in der Mongolei, 35-р тал.

Ардчиллын нэг түшиг тулгуур бол ардчилсан боловсролтой иргэд юм. Иймд Монгол хүн бүр ардчиллын боловсролоор тэтгэгдэж байх ёстой.

Зохиогч